

ХУЛД СУМЫН ХАБЭА-Н САЛБАР ЗӨВЛӨЛӨӨС "ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН САРЫН АЯН"-Ы ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2023 оны 04 сарын 28

Улаанжирэм

Сумын ХАБЭА-н зөвлөл 2023 оны 04 сарын 11-нд хуралдан, ХАБЭА-н сарын аяны хүрээнд болон, сумын ХАБЭА-н зөвлөлийн 2023 онд хийх ажлын төлөвлөгөөгөө ярилцан санал солилцож, сумын Засаг даргын орлогч, ХАБЭА-н зөвлөлийн даргаар батлуулсан. Энэ жил суманд Онцгой байдлын Эрэн хайх аврах бүлэг шинээр байгуулагдсан тул ХАБЭА-н зөвлөлд даргыг оруулан, Засаг даргын захирамжаар зөвлөлөө шинэчилсэн. Төсвийн бүх байгууллага, сумын ХАБЭА-н зөвлөлийн гишүүд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны хүрээнд хийх ажлын төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж, санаачлан зохион байгуулсан ажлын тайлангаа хугацаандаа ирүүлсэн. Энэ жилийн сарын аяны хүрээнд 14 ажил төлөвлөн 1 ажлыг түр хойшлуулсан. Зөвлөлийн гишүүд ажлаа долоо долоо хоногоор хариуцан зохион байгуулсан. 1-р 7 хоногийг Эмнэлэг, соёлын төв, 2-р долоо хоногийг сургууль, цэцэрлэг, 3-р долоо хоногийг Тамгын газар, Үйлдэрчний эвлэлийн хороо хариуцан авч, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаа хийж гүйцэтгэсэн.

Сарын аяны нээлтээ сумын соёлын төвд хийсэн. Суманд шинээр байгуулагдсан Эрэн хайх аврах бүлгээс аюулгүй ажиллагааны талаар сургалт зохион байгуулж, аюулт үзэгдэл, ослын үед хэрэглэх тоног төхөөрөмж, хувцас хэрэглэлээ танилцуулсан. Үзүүлэн гаргасан.

Эрүүл мэндийн төв, цэцэрлэгээс ажилчиддаа шинээр авч өгсөн нормын хувцсаа мөн дэлгэн тавьж сурталчилсан.



Зөвлөлийн дарга Б.Болормаа, нарийн бичгийн дарга А.Нямцэрэн нар үг хэлж, төлөвлөгөө танилцуулсан.





Нээлтэнд Соёлын төвийн ХАБЭА-н зөвлөлийн дарга Б.Батцэцэг, ЭХАБ-ийн ажилтан нар сургалт хийсэн.

Энэ жилийн онцлох ажлууд:

2022 оны “Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага”-аар шалгарсан “Өлзийт мандал” өрхийн эмнэлгийн туршлагыг зөвлөлийн гишүүд, эрүүл мэндийн төвийн ажилчдаас бүрдсэн 10 хүний бүрэлдэхүүнтэй судалсан. Мөн энэ үеэрээ тусгай хөтөлбөрийн дагуу аймгийн ХАБЭА-н зөвлөлтэй хамтран хэлэлцүүлэг зохион байгуулж, сургалт авсан. Үүний үр дүнд зөвлөлийн гишүүн бүр сум, байгууллагадаа хийх ажил, судлах дүрэм, журмын жагсаалт гарган, төлөвлөгөөндөө тусган хэрэгжилтийг хангасан. Уг арга хэмжээ зохион байгуулахад сумын Засаг даргаас 170,0 мян төгрөгний дэмжлэг үзүүлж, байгууллагуудын ХАБЭА-н зөвлөл бензиний зардал гарган дэмжсэн.



Аймаг, сумын ХАБЭА-н зөвлөлийн гишүүд



Туршлага судлах үеэр

ХАБЭА-н сарын аяны хүрээнд хийсэн ажил, холбогдох хууль тогтоомж, аюулгүй ажиллагааны талаарх бусад мэдээ мэдээллээ “Хулд сумын ХАБЭА-н салбар зөвлөл” “Хулд сумын ЗДТГ” “Ајііһаһ” зэрэг цахим хуудсаар тавьж сурталчилсан.



Аяны хугацаанд аймгийн ХАБЭА-н зөвлөлийн гишүүд, Үйлдвэрчний эвлэлийн хорооноос сумын ХАБЭА-н зөвлөлийн дарга, гишүүд, байгууллагын зөвлөлийн гишүүд, ҮОХХСБК-ын гишүүдэд 2 удаа сургалт авсан.




Тамгын газар, Сургууль, цэцэрлэг, соёлын төв зэрэг байгууллагууд ХАБЭА-н зөвлөл, ҮОХХСБК-оо шинэчлэн тушаал захирамж гаргасан.

Сайнцагаан сумын ХАБЭА-н зөвлөлийн гишүүд ирж туршлага судалсан. Тусгай хөтөлбөр гарган байгууллага бүр сайн туршлагаасаа танилцуулан ажлаа сурталчилж, дотор ,гадна орчин, сарын аяны хүрээнд хийсэн шинэлэг ажлаа цаашид төсөв санхүүгийн талаар болон анхаарах асуудлын талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан. Аймгийн ХАБЭА-н зөвлөлийн гишүүн, ҮЭ-ийн хорооны дарга Б.Мөнхчулуун 2 сумын гишүүдэд ХАБЭА, ҮОХХСБК-ын талаар сургалт явуулсан.



ХАБЭА-н зөвлөлийн бүх гишүүд өөрийн сайн туршлагаасаа хуваалцсан

Сургууль, цэцэрлэгийн ХАБЭА-н зөвлөлөөс хүүхэд, эцэг эхчүүдийн дунд осол аюулаас урьдчилан сэргийлэх, гэмтсэн үед анхны тусламж үзүүлэх, эрүүл аж төрөх талаар үзүүлэх тоглолт зохион байгуулсан. Цэцэрлэгийн 25, сургуулийн 86 хүүхэд оролцон тоглосон. Мөн сургуулийн хүүхдүүд үзүүлэн таниулах материал бэлдэж гаргасан. Байгууллагын ХАБЭА-н зөвлөлөөс оролцсон хүүхэд байгачуудаа урамшуулсан.



Сургууль цэцэрлэгийн хүүхдийн үзүүлэх тоглолтоос



Оролцсон хүүхдүүдэд “Талархал” хадгалуулсан.

Энэ сарын аянаар бүх байгууллага самбараа шинэчлэх, тэмдэг тэмдэглэгээ хийх, галын схем, галын хор байрлуулах зэрэг ажлыг сайн хийж гүйцэтгэсэн.



Бүх байгууллага эмийн сан, термометрийг байгууллагадаа байршуулсан.



Сумын ХАБЭА-н зөвлөлийн гишүүд бүх байгууллага, ААН-ээр орж биенээсээ санаа авч, дутагдалтай зүйлийг хэлж засуулан, байгууллага дээрээ нийцлийн үнэлгээ хийсэн нь үр дүнтэй ажил болсон.



Сумын ҮЭ-ийн хорооноос иргэдийн дунд арга хэмжээ зохион байгуулж, аяны хаалтаа хийсэн. “Эрүүл аюулгүй ажил-бидний суурь эрх” фото челеенжид нэгдэх, оролцогсдод ажлын байрны дасгал хөдөлгөөн, бүжгээр эрүүлжихийн ач тус ойлгуулж бүжиг заах, хөгжөөнт тоглоом тоглуулах зэргээр хөтөлбөрийн дагуу сайхан арга хэмжээ зохион байгуулсан. ХАБЭА-н талаар гарын авлага тараах, шторк бэлдэж үзүүлэх, самбараар тараах материал бэлтгэн байршуулах зэргээр сурталчилгаа хийсэн.



Сарын аяны хаалт





Фото чөлөөжид нэгдэх арга хэмжээ

Байгууллагуудын ХАБЭА-н зөвлөл бүгд сарын аяны хүрээнд хийх ажлын төлөвлөгөө гарган, гүйцэтгэсэн ажлын тайлангаа хугацаанд нь ирүүлсэн.

Цэцэрлэгийн хийсэн ажлаас:

- Тусгай утас ажиллуулж эхэлсэн. 99824068
- “Миний гэр аюулгүй орчин” уриан дор 14 багш ажилчид гэртээ эрсдлийн үнэлгээ хийж, эрсдлээ бууруулах арга хэмжээ авсан.
- Хүүхдээ цэцэрлэг, сургуульд хүргэдэг 20 машинд “Хүүхэд зорчиж байна” тэмдэг тавьж өгсөн.
- Тэмдэг тэмдэглэгээг хуучин монголоор бичиж хадсан.
- Тог цахилгаанаас болгоомжлох 32 санамж тавьсан.
- Сургууль, цэцэрлэг орчим замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор замын тэмдэг хийж байршуулсан.

Соёлын төвийн хийсэн ажлаас:

- Самбар булан тэмдэг тэмдэглэгээгээ шинэчилсэн.
- Хувиараа гагнуур хийдэг иргэдэд гагнуур хийх үеийн аюулгүй ажиллагаа, цахилгаан багажтай аюулгүй ажиллах талаар зааварчилгаа бэлдэж тараасан
- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяныг дэлхийн бүжгийн өдөртэй уялдуулан ахмадууд, иргэдийн дунд нийтийн цэнгээнт бүжгийн сургалт явуулж, 3 бүжиг заан 124 хүн хамруулсан.

Эмнэлгийн ажлаас:

- ҮОХХСБК-ыг 3 хүний бүрэлдэхүүнтэй шинэчилсэн.
- Сэргээн засахын өрөөний тоног төхөрөмжид тавиур хийлгэсэн.
- Ажилчиддаа гал унтраах багаж хэрэгсэл, галын хортой ажиллах талаар Онцгой байдлын газраас сургалт авсан.
- Тэмдэг тэмдэглэгээг бүгдийг шинэчилсэн.
- Ажлын байран дах аюулыг мэдээлэх санал хүсэлтийн хайрцаг байрлуулсан.

Сургуулийн ажлаас:

- Эцэг эхийн сурган хүмүүжүүлэх өдөрлөгөөр 12 бүлгийн 100 хүүхдийг төлөөлсөн 56 эцэг эхэд “Цахим хэрэглээг зохистой хэрэглэх” сэдэвт сургалтыг зохион явуулсан.

- Сургалтын материал, гарын авлага боловсруулж тараав.



Тамгын газрын ажлаас:

- ХАБЭА-н самбар, галын аюулын самбар, гарцын схемтэй болсон.
- Бүх газартаа тэмдэг, тэмдэглэгээ байршуулсан.
- Бүх өрөөг термометржүүлж, байгууллага эмийн сантай болсон



Сумын Үйлдвэрчний эвлэлийн хорооноос:

- Сумын ҮЭХ-ны тэргүүлэгчийн хурлаар ХАБЭА-н сарын аяны хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан хэлэлцэж батлав.
- Удирдамжийн дагуу сумын ХАБЭА-н салбар зөвлөлтэй хамтран ЕБСургууль, соёлын төв, цэцэрлэг, эрүүл мэндийн төв, ЗДТГ зэрэг төсвийн байгууллагуудад ХАБЭА-н тухай хуулийн 26-ийн 2 дахь заалтыг хэрэгжүүлж буй байдалд үзлэг хийсэн. Үзлэгийн үр дүнгийн талаар аймгийн болон сумын ҮЭ-н холбоо, ХАБЭА-н зөвлөлийн гишүүдэд хэлэлцүүлэг явуулж, холбогдох байгууллагад хүргүүлэх тухай санал бодлоо солилцсон.



- Сумын ҮЭ-н холбооноос иргэд, хөдөлмөрчид, гишүүдийн дунд “Эрүүл аюулгүй ажлын байрны төлөө” сэдэвт цэнгүүнийг зохион байгууллаа.



- Иргэд хөдөлмөрчдөд ХАБЭА-н хуулийг сурталчлах зорилгоор байгууллагууд “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, галын аюулаас урьдчилан сэргийлэх”, “Ажлын байрны онцгой 10 дасгал”, “Хүүхдийг осол гэмтлээс сэргийлэх зөвлөмж”, “Хийн зуухыг зөв ашиглах зөвлөмж”, “Гагнуурчны аюулгүй ажиллах заавар” 150 гаруй сурталчилгааны материал бэлтгэн тарааж “Галын аюулгүй байдал”-ын талаар видео бичлэг үзүүлсэн.



ТАЙЛАН БИЧСЭН: ХУЛД СУМЫН ХАБЭА-Н ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
А.НЯМЦЭРЭН